



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/58

Мандалговь

Баримт нягтлан шалгах  
арга зүйн комисс байгуулах тухай

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөмрөг үүсгэгч байгууллагын баримтын агуулга, бүрэлдэхүүнийг тодорхойлох, баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтанд баримт сонгож авах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: -Хяналт - шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Гишүүд:

- Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл урлаг, спортын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Барилга хот байгуулалт, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дотоод ажил, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг: - Архивын тасгийн дарга

2. Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, тус тусад нь төрөлжүүлж, хэргийн хадгалах хугацааг зөв тогтоосон эсэх талаар нягтлан шалгах ажлыг архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу зохион байгуулахыг комиссын даргад үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/50 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ



4822150122